



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/459

Хэрлэн сум

Үндсэн хөрөнгө акталж,
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журам, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Долоодугаар хуралдааны 2025 оны 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 11 нэрийн 236,916,635 (хоёр зуун гучин зургаан сая есөн зуун арван зургаан мянга зургаан зуун гучин тав) төгрөгийн балансын үнэтэй, 93,877,156.04 (ерэн гурван сая найман зуун далан долоон мянга нэг зуун тавин зургаан төгрөг тэг дөрөв) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий 143,039,478.96 (нэг зуун дөчин гурван сая гучин есөн мянга дөрвөн зуун далан найман төгрөг ерэн зургаа) мөнгөний үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгүүдийг актлахыг зөвшөөрч, жагсаалтыг хавсралтад дурдсанаар баталсугай.

2.Данснаас хассан тээврийн хэрэгслийг авто тээвэр, барилга байгууламжийг татвар төлөгчийн бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Д.Билгээ)-д, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



دست / مست

[illegible][illegible][illegible]

مجلس

Үндсэн хөрөнгө ахтлах жагсаалт

№	Байгууллагын нэр	Нэр төрөл	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Ашиглах хугацаа	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Цагдаагийн газар	1	УАЗ Пургон(65-25ХЭА)	2018	5	1	29,700,000	6,435,000.00	23,265,000.00
		1	УАЗ Хантер (83-29ХЭУ)	2016	1	1	500,000		500,000.00
		1	Дадал-Кабон барилга	2010	30	1	55,727,935	26,470,769.22	29,257,165.78
2	Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төв	1	УАЗ-469 (1510 ХЭУ)	2016	6	1	30,000,000	30,000,000	0.00
		1	Мотоцикль	2017	6	1	1,800,000	1,800,000	0.00
3	Тавдугаар цэцэрлэг	1	Склад	1979	15	1	264,600	264,600	0.00
		1	Сүүдрэвч	2009	5	1	465,000	465,000	0.00
		1	Сүүдрэвч том	2013	10	1	500,000	500,000	0
4	Наймдугаар цэцэрлэг	1	Сүүдрэвч жижиг	2013	10	1	400,000	400,000	0
		1	Нийтлэг үйлчилгээний барилга	1960	46	1	100,359,100	10,341,786.82	90,017,313.18
5	Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар	1	Нийтлэг үйлчилгээний барилга	1960	46	1	100,359,100	10,341,786.82	90,017,313.18
		1	Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар	2013	6	1	17,200,000	17,200,000	-
6		11	Кама хотны машин (38-70ХЭУ)	2013	6	1	17,200,000	17,200,000	-
							236,916,635	93,877,156.04	143,039,478.96

2025 оны 08 дугаар сарын 21-ны өдөр
Аймгийн Засаг даргын Тамгын газар
Хүрээмжтэй хавсралт